



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2022/127/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: atjargalo@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Аудитор: Ө.Ринчинмядаг Утас: 70323108 Цахим хаяг: rinchinmyadagu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

1.Аудитын гэрчилгээ



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.12 № 11
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
Б.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

016030023

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,142,717.46	30,934,476.22
35	БАРАА МАТЕРИАЛ	61,142,717.46	30,934,476.22
351	Түүхий эд материал	47,198,259.46	20,105,496.22
35110	Тусгай зориулалттай материал	47,198,259.46	20,105,496.22
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,505,000.00	2,313,000.00
354	Хангамжийн материал	10,439,458.00	8,515,980.00
35410	Бичиг хэргийн материал	188,200.00	171,600.00
35420	Аж ахуйн материал	853,778.00	987,700.00
35470	Бусад хангамжийн материал	9,397,480.00	7,356,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,052,959,963.23	1,179,375,322.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,052,959,963.23	1,179,375,322.95
392	Биет хөрөнгө	606,182,043.23	732,322,402.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	360,613,249.00	375,613,249.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,865,628.56	-42,977,481.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,477,573.78	72,227,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,554,482.24	-22,993,446.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	740,690,972.26	514,262,015.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-529,416,911.40	-174,592,042.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,620,819.00	32,381,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,383,548.61	-21,598,464.57
393	Биет бус хөрөнгө	446,777,920.00	447,052,920.00
39301	Програм хангамж	200,000.00	475,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	446,777,920.00	446,777,920.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,114,102,680.69	1,210,309,799.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,114,102,680.69	1,210,309,799.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,114,102,680.69	1,210,309,799.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,589,667,302.02	1,589,667,302.02
51101	Өмч: - төрийн	1,589,667,302.02	1,589,667,302.02
512	Хуримтлагдсан үр дүн	-570,662,061.65	-470,394,730.53
51210	Өмнөх үеийн үр дүн	-570,662,061.65	-566,601,849.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	96,207,118.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	95,097,440.32	91,037,227.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,114,102,680.69	1,210,309,799.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,501,684,338.87	1,453,549,516.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	241,601,583.87	229,192,371.09
120	Нийтлэг татварын бус орлого	241,601,583.87	229,192,371.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	241,601,583.87	229,192,371.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,046,200.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	954,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,260,082,755.00	1,224,357,145.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,246,854,700.00	1,188,864,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,246,854,700.00	1,188,864,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,228,055.00	35,492,345.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,728,055.00	20,434,595.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	5,057,750.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,375,875,669.31	1,357,342,397.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,875,669.31	1,357,342,397.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,270,452,058.79	1,295,047,566.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	968,435,855.00	957,116,451.00
210101	Үндсэн цалин	685,040,755.00	681,179,205.49
210102	Нэмэгдэл	254,237,100.00	246,813,245.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,158,000.00	29,123,999.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,877,620.48	128,396,528.00
210201	Тэтгэврийн даатгал	87,995,120.48	89,913,813.73
210202	Тэтгэмжийн даатгал	9,720,600.00	9,720,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,776,500.00	7,776,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,944,100.00	1,892,517.92
210205	Эрүүл мэндийн даатгал	19,441,300.00	19,093,096.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,096,007.00	22,878,880.00
210301	Гэрэл, цахилгаан	11,942,100.00	11,133,700.00
210302	Түлш, халаалт	11,606,050.00	11,372,540.00
210303	Цэвэр, бохир ус	547,857.00	372,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,853,662.00	14,974,748.00
210401	Бичиг хэрэг	2,650,950.00	2,755,515.00
210402	Тээвэр, шатахуун	7,866,235.00	5,828,755.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,979,530.00	3,798,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	356,947.00	229,878.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,362,200.00
2105	Нормативт зардал	1,060,000.00	222,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,060,000.00	222,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,803,722.00	6,193,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	206,000.00	00.00
210604	Урсгал засвар	6,597,722.00	6,193,100.00
2107	Томилолт, зочны зардал	5,432,000.00	4,748,000.00
210702	Дотоод албан томилолт	5,432,000.00	4,748,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,992,383.20	109,947,183.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,809,383.20	106,402,433.49
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	00.00

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	407,000.00	407,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,000.00	130,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210807	Газрын төлбөр	495,000.00	2,974,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,900,809.11	50,570,526.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	419,500.00	420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,481,309.11	50,150,526.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,423,610.52	62,294,831.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,812,400.00	43,988,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,812,400.00	43,988,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,611,210.52	18,306,531.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,611,210.52	18,306,531.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	125,808,669.56	96,207,118.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	125,808,669.56	96,207,118.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,262,128,955	1,225,311,145
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	502,000	954,000
3	Нийтлэг татварын бус орлого	502,000	954,000
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	502,000	954,000
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	502,000	954,000
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,261,626,955	1,224,357,145
7	Улсын төвлөрсөн төсвөөс	1,246,854,700	1,188,864,800
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,246,854,700	1,188,864,800
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,772,255	35,492,345
10	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000	10,000,000
11	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,228,055	20,434,595
12	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,044,200	5,057,750
13	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,261,328,955	1,206,259,145
14	УРСГАЛ ЗАРДАЛ	1,261,328,955	1,206,259,145
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,905,344.48	1,143,964,314
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	968,435,855	957,116,451
17	Үндсэн цалин	685,040,755	681,179,205.49
18	Нэмэгдэл	254,237,100	246,813,245.96
19	Унаа хоолны хөнгөлөлт	29,158,000	29,123,999.55
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,877,620.48	128,396,528
21	Тэтгэврийн даатгал	87,995,120.48	89,913,813.73
22	Тэтгэмжийн даатгал	9,720,600	9,720,600
23	ҮОМШӨ-ний даатгал	7,776,500	7,776,500
24	Ажилгүйдлийн даатгал	1,944,100	1,892,517.92
25	Эрүүл мэндийн даатгал	19,441,300	19,093,096.35
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,079,257	22,813,845

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

27	Гэрэл, цахилгаан	11,942,100	11,133,700
28	Түлш, халаалт	12,589,300	11,307,505
29	Цэвэр, бохир ус	547,857	372,640
30	Хангамж, бараа материалын зардал	13,052,062	12,606,670
31	Бичиг хэрэг	2,504,550	2,738,915
32	Тээвэр, шатахуун	7,866,235	5,828,755
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,979,530	3,798,400
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	701,747	240,600
35	Нормативт зардал	3,374,600	407,650
36	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,374,600	407,650
37	Эд хогшил, урсгал засварын зардал	5,690,650	6,188,200
38	Багаж, техник, хэрэгсэл	206,000	
39	Урсгал засвар	5,484,650	6,188,200
40	Томилолт, зочны зардал	5,432,000	4,748,000
41	Дотоод албан томилолт	5,432,000	4,748,000
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,543,800	11,266,970
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,360,800	7,722,220
44	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000	
45	Даатгалын үйлчилгээ	407,000	407,000
46	Тээврийн хэрэгслийн татвар	83,000	130,000
47	Тээврийн хэрэгслийн оношлогоо		33,000
48	Газрын төлбөр	495,000	2,974,750
49	Бараа үйлчилгээний бусад зардал	419,500	420,000
50	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	419,500	420,000
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,423,610.52	62,294,831
52	Бусад урсгал шилжүүлэг	96,812,400	43,988,300
53	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,812,400	43,988,300
54	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,611,210.52	18,306,531
55	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,611,210.52	18,306,531
56	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	800,000	19,052,000
57	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	800,000	19,052,000
58	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	800,000	19,052,000
59	Дотоод эх үүсвэрээр	800,000	19,052,000
60	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	800,000	19,052,000
61	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-800,000	-19,052,000
62	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,589,667,302.02	98,945,499.10	-700,318,789.99	00.0	988,294,011.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.0	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,589,667,302.02	98,945,499.10	-700,318,789.99	00.0	988,294,011.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.0	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.0	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.0	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	65,914,308.23	00.0	65,914,308.23
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,589,667,302.02	95,097,440.32	-570,662,061.65	00.0	1,114,102,680.69
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,589,667,302.02	95,097,440.32	-570,662,061.65	00.0	1,114,102,680.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,060,212.64	00.0	4,060,212.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,589,667,302.02	95,097,440.32	-566,601,849.01	00.0	1,118,162,893.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-4,060,212.64	00.00	00.0	-4,060,212.64
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.0	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.0	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.0	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,207,118.48	00.0	96,207,118.48
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,589,667,302.02	91,037,227.68	-470,394,730.53	00.0	1,210,309,799.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,247,354,700	1,238,745,489.48	1,189,364,800	1,171,512,269
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,247,354,700	1,238,745,489.48	1,189,364,800	1,171,512,269
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,150,542,300	1,141,933,089.48	1,145,376,500	1,127,523,969
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,064,400	968,435,855.00	972,064,400	957,116,451
210101	Үндсэн цалин	688,669,300	685,040,755.00	689,376,000	681,179,205

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	254,237,100	254,237,100.00	253,530,400	246,813,246
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,158,000	29,158,000.00	29,158,000	29,124,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,228,700	126,877,620.48	131,228,600	128,396,528
210201	Тэтгэврийн даатгал	92,346,200	87,995,120.48	92,346,100	89,913,814
210202	Тэтгэмжийн даатгал	9,720,600	9,720,600.00	9,720,600	9,720,600
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,776,500	7,776,500.00	7,776,500	7,776,500
210204	Ажилгүйдлийн даатгал	1,944,100	1,944,100.00	1,944,100	1,892,518
210205	Эрүүл мэндийн даатгал	19,441,300	19,441,300.00	19,441,300	19,093,096
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,562,700	25,079,257.00	22,818,100	22,813,845
210301	Гэрэл, цахилгаан	11,942,100	11,942,100.00	11,133,700	11,133,700
210302	Түлш, халаалт	12,589,300	12,589,300.00	11,311,400	11,307,505
210303	Цэвэр, бохир ус	1,031,300	547,857.00	373,000	372,640
2104	Хангамж, бараа материалын зардал	7,614,200	7,602,257.00	5,894,800	5,892,275
210401	Бичиг хэрэг	874,800	874,800.00	1,509,800	1,509,115
210402	Тээвэр, шатахуун	4,050,300	4,046,180.00	3,094,200	3,094,160
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,986,700	1,979,530.00	1,048,400	1,048,400
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	702,400	701,747.00	242,400	240,600
2105	Нормативт зардал	1,374,600	1,374,600.00	407,700	407,650
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,374,600	1,374,600.00	407,700	407,650
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,836,000	1,832,200.00	1,836,000	1,826,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,009,800	1,006,000.00	1,009,800	1,000,000
210604	Урсгал засвар	826,200	826,200.00	826,200	826,200
2107	Томилолт, зочны зардал	2,774,000	2,768,000.00	2,539,200	2,528,000
210702	Дотоод албан томилолт	2,774,000	2,768,000.00	2,539,200	2,528,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,667,000	7,543,800.00	8,167,000	8,123,020
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,360,800	6,360,800.00	6,343,000	6,342,220
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000	198,000.00	00	00
210803	Даатгалын үйлчилгээ	407,000	407,000.00	407,000	407,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,800	83,000.00	151,800	130,000
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,400	00.00	54,400	33,000
210807	Газрын төлбөр	495,000	495,000.00	1,210,800	1,210,800
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,700	419,500.00	420,700	420,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,700	419,500.00	420,700	420,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,812,400	96812400.00	43,988,300	43,988,300

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	96,812,400	96,812,400.00	43,988,300	43,988,300
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,812,400	96,812,400.00	43,988,300	43,988,300
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,247,354,700	1,238,745,489.48	1,189,364,800	1,171,512,269
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,246,854,700	1,238,243,489.48	1,188,864,800	1,170,558,269
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,246,854,700	1,238,243,489.48	1,188,864,800	1,170,558,269
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000	502,000.00	500,000	954,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000	502,000.00	00	00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00	00.00	500,000	954,000
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	85	85.00	85	85
620001	Удирдах ажилтан	01	01.00	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	82	82.00	82	82
620003	Үйлчлэх ажилтан	02	02.00	02	02

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,673,100	35,492,345
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,673,100	35,492,345
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,673,100	35,492,345
2104	Хангамж, бараа материалын зардал	4,388,800	6,714,395
210401	Бичиг хэрэг	1,448,800	1,229,800
210402	Тээвэр, шатахуун	2,940,000	2,734,595
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00	2,750,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,596,300	23,414,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	00	3,052,000
210604	Урсгал засвар	1,596,300	20,362,000
2107	Томилолт, зочны зардал	1,688,000	2,220,000
210702	Дотоод албан томилолт	1,688,000	2,220,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00	3,143,950
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	3,143,950
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,673,100	35,492,345
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,673,100	35,492,345
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000	10,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00	20,434,595
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,673,100	5,057,750

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Ө.Ринчинмядаг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.05-ний өдрийн 01/03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Ус, цаг уур, байгаль орчны чанарын мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын нэгж 2013 онд байгуулагдан, 2019 онд шинэчлэгдсэн бөгөөд 3 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг.

УЦУОШТөвийн салбаруудад 2021 онд дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөг батлан, гүйцэтгэлийг тайлагнасан байна. 2021 онд 20 салбарт давхардсан тоогоор 38 удаагийн шалган туслах ажил хийж 26 төрлийн 49 үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйцээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1,453.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд БОАЖС-ын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар батлагдан Хархорин сумын Цаг уурын өртөөний барилгын их засварт 15.0 сая төгрөг зарцуулагдан бүртгэлд тусгасан.

Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан үзэхэд тусгай зориулалттай материалын үлдэгдэл 27.1 сая төгрөгөөр буурсан өөрчлөлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 1,188.86 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.954 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 4.6 хувиар буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 1,171.5 сая төгрөгөөр санхүүжигдэн, 1,171.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 35.492 сая төгрөгийг урсгал засвар, тоног төхөөрөмж, хангамжийн бараа материалын зардалд тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд түлш, халаалтын зардлаас зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэн. Мөн дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг олон нийтэд бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллын 2020 оны санхүүгийн тайланд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 96.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 2.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Зөрчлийг арилгаж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.47 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

4.3 Албан шаардлага

Түлш, халаалтын зардлаас 0.47 сая төгрөгийг түлш, халаалттай холбоотой засвар үйлчилгээний зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.

4.4 Зөвлөмж

Байхгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	1	0.47	0	0	0	0	1	0.47	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР